МАНАЙ СОНИНЫ III УЛИРЛЫН ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

MMINFO.

18 дахь жилдээ **МОНГОЛЫН МЭДЭЭ**

Хүн ам 3,091,292... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.06.28. Мягмар. №130 (4500) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




СОНГОГЧИЙН БОЛОВСРОЛД

САНАЛАА ХЭРХЭН ӨГӨХ ВЭ

II нүүрт

Дугаарын 60 мөр

## Сонгуулиа өгцгөөе, залуус аа

Н.ПУНЦАГБОЛД

Парламентын ээлжит сонгууль маргааш болно. Өглөө 07:00 цагаас санал хураалт эхэлж, орой 22:00 цагт өндөрлөх учиртай. Бид дөрвөн жилийн хугацаанд төрд төлөөллөө илгээх эрхээ ийм багахан хугацаанд л эдэлдэг. Ердөө л ганц өдөр бид сонголтоо зөв хийж, сонгуульдаа идэвхтэй оролцсоноор дөрвөн жил үр шимийг нь үзэх ёстой юм. Гэтэл манай залуучууд сонгууль өгнө гэдгийг ард түмэн төр барих эрхээ эдэлж байгаа нэг хэлбэр гэдгийг ойлгохгүй байна. Нөгөө талаасаа хэтэрхий хариуцлагагүй, мэдлэг мэдээлэлгүй, залхуу хойрго хандаж байгаа юм. Сонгууль өгөөд яах юм, хэрэггүй. Аль нь ч гарсан ялгаагүй, бүгд адилхан. Төрд гарсан болгон нь муу гэдэг явцуу нэг л ойлголттой болчихож. Тэгсэн мөртлөө сонгуулийн дараа ялсан, олонхи болсон, дөрвөн жил төр барьсан нам, улс төрийн хүчин, эвсэл, гишүүдийг муулдаг.

**Үргэлжлэл нь III нүүрт**

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

# НААДМЫН ГОЁЛОО ЗЭХЭЖ АМЖСАН УУ

–Энэ жил энгийн “универсиал” дээл модонд орж, завсрын өнгө давамгайлах нь–

Х.НАРАНЦАЦРАЛ
Н.САРНАЙ
Б.НОМИН

Уул тал мөнх ногоон нөмрөгөө нөмөрч, хаа нэг хур бороо шаагин зуны дунд сар гарч аль хэдийнэ үндэсний их баяр наадам хаяанд иржээ. Энэ өдрүүдэд хөдөө нутагт хүүхэд багачуудын гийнгоон дуу цангинаж, уяа тойрч морь шинжсэн халуун яриа өрнөж байхад хот газарт наадмын нээлтийн үйл ажиллагааны бэлтгэл ажил ид өрнөхийн зэрэгцээ наадмын гоёлууд ч аль хэдийнэ гарч, хэн хүний нүдийг булааж эхэллээ. Монголын уламжлалт эрийн гурван наадмыг үндэсний хувцас болох монгол дээлгүйгээр төсөөлөхийн аргагүй. Гадаад дотоодын жуулчдын харааг булааж, нүдийг хужирлах наадмын нэгэн чимэг нь монгол дизайнеруудын ур ухаанаа гаргаж урласан монгол дээл байдаг. Тэгвэл үндэсний дээл жил ирэх тусам өнгө үзэмж, чанар, материал загварын хувьд өөрчлөгдөн улам дэгжин болсоор буй. Үүнийг дагаад хэрэглэгчид ч хамгийн загварлаг басхүү чанартай дээл өмсөхийг хүсэх болсон. Тиймээс бид энэ жилийн наадмын дээлний трэнд өнгө болон загварын талаар сурвалжиллаа.

### Монгол дээл 1.5 саяар үнэлэгдэв

Бидний хамгийн түрүүнд очсон газар бол 16 жилийн түүхтэй “Торго” салон. Тус салоны үүдээр ормогц л өнгө өнгийн торго нүд гялбуулж, дизайнеруудынх нь урласан төрөл бүрийн загварыг шингээсэн дээлнүүд анхаарал татаж байв. Энэ жилийн монгол дээлний загварын каталогид 300 гаруй шинэ загварын хувцас орсон бөгөөд Н, А хэлбэрийн сонгодог стилийг хослуулсан холимог загварууд зонхилж байгаа гэнэ. Харин өнгөний хувьд цайвар цэнхэр, саарал, бор зэрэг завсрын өнгө трэнд болж байгаа аж.

**Үргэлжлэл нь IV-V нүүрт**



# ТҮҮХЭНД БАЙГААГҮЙ ОЛОН ТАМИРЧИН РИО-Г ДАЙЛААР МОРДОНО

Rio2016

Н.ПУНЦАГ

Хүн төрөлхтний их баяр цэнгэл, зуны олимпийн 31 дэх наадам эхлэхэд ердөө л 37 хоног үлдээд байна. Олимпийн эрх олгох тэмцээнүүд ерөнхийдөө өндөрлөж, Риог зорих тамирчдын нэр эцэслэн тодорч эхэллээ. Одоо жүдогийн тамирчид Улаанбаатарт нэг чуулна. Мөн “Их дуулга” ангиллын нэг тэмцээн байгаа. Тэгээд л Олимптой золгоно. Манайхны хамгийн их найдлага тавьдаг чөлөөт, бөхийн буудлага, боксын тамирчдын хувьд Олимпийн эрх олгох тэмцээнүүд дууссан. Хамгийн бахархуулмаар нь Монголын тамирчид Рио-2016 Олимпийн наадамд түүхэнд байгаагүй олон хүний бүрэлдэхүүнтэй оролцохоор болоод байна. Манай улс ердөө л 10 гаруйхан, сайндаа л 20 давсан хүний бүрэлдэхүүнтэй Олимпийн наадамд оролцдог байсан цаг саяхан. Лондонгийн Олимпийн наадамд манайхан 29 тамирчин оролцуулж байсан нь гайхалтай амжилтаар нэрлэгдэж, шуугиулж байсан шүү дээ. Тэгвэл Рио-гийн Олимпийн наадамд 40 орчим хүний бүрэлдэхүүнтэй оролцох нь. Ямар ч байсан албан ёсоор Олимпийн эрхээ авсан 36 тамирчин байгаа юм. Уг нь 37 байснаас чөлөөтийн нэг тамирчин допинг хэрэглэсэн гэх шалтгаанаар эрхээ хураалгасан билээ. Тэгвэл усанд сэлэлтийн хоёр тамирчин цагаан хуудсаар Олимпийн наадамд оролцоно.

**Үргэлжлэл нь III нүүрт**







**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 1943.00 | 1963.00 | ФУНТ | 2561.00 | 2651.00 |
| ЕВРО | 2122.00 | 2183.00 | РУБЛЬ | 28.00 | 31.90 |
| ИЕН | 18.90 | 19.48 | ЮАНЬ | 291.00 | 296.30 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 1947.00 | 1963.00 | ФУНТ | 2576.00 | 2657.00 |
| ЕВРО | 2124.00 | 2189.00 | РУБЛЬ | 28.80 | 31.60 |
| ИЕН | 18.88 | 19.52 | ЮАНЬ | 293.30 | 297.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

ЧУУЛГАН

## Хаврын ээлжит чуулганы өнөөдөр хаана

УИХ-ын дарга захирамж гаргаж, тавдугаар сарын 23-нд УИХ-ын чуулганы хуралдааныг нэг сарын хугацаанд түр завсарлуулах шийдвэр гаргасан билээ. Хуралдааныг завсарлуулах болсон шалтгаанаа УИХ-ын дарга улстөржилт их байгаа учраас улсын ажлыг хэлэлцэхгүй нь тодорхой байна хэмээн тайлбарлаж байсан. Уг нь хуваарь ёсоор хуралдаан энэ сарын 24-нд хуралдах байсан ч ирц бүрдээгүй юм. УИХ-ын гишүүдийн дийлэнх нь дахин нэр дэвшиж, тойрогтоо сурталчилгаа хийж байгаа учраас хуралд оролцох гишүүн ирээгүй юм. Тэгвэл УИХ-ын даргын дэргэдэх зөвлөл энэ сарын 24-нд хуралдаж 2016 оны хаврын ээлжит чуулганыг өнөөдөр хаахаар болсон байна. Хаврын чуулганы сүүлийн хуралдаан нь өнөөдөр 09:00 цагт эхлэх бөгөөд Хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсч, 2016 оны хаврын ээлжит чуулганы хаалт хийх аж. Тодруулбал, маргаашийн чуулганаар Батлан хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга, Зэвсэгт хүчний тухай хууль, Цэргийн албаны тухай, Цэргийн албан хаагчийн эрхзүйн байдлын тухай болон бусад хуулийн төслүүдийг эцэслэн хэлэлцэх учиртай. Мөн Тахарын албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон дагалдан өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төслийг тус тус хэлэлцэхээр болжээ.


mminfo.mn
Шударга, Шуурхай, Онцгой мэдээлэл

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч:
С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч
Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:
Э.ЭНХЦЭЦЭГ
88873012

Ахлах редактор:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба
Н.ПУНЦАГБОЛД
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Гэрэл зургийн алба:
Г.АРГУУЖИН
96017873

Компьютерийн алба:
Б.ГАНЗОРИГ
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба:
Н.АЛТАНЦЭЦЭГ
99173710

Захиалга, борлуулалтын алба:
М.ДАВААДУЛАМ
99042510

Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхэлсэн
Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс:
976-70113551

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.


СОНГОГЧИЙН БОЛОВСРОЛД

# САНАЛАА ХЭРХЭН ӨГӨХ ВЭ




*Санал өгөх байранд туршилт явуулав /2016.06.24/*

Б.ТОГТОХ

*Маргааш монголчууд бүх нийтээрээ УИХ-ын болон аймаг нийслэлд өөрсдийг нь төлөөлж суух төрийн төлөөллөө сонгох гэж байна. Нэр дэвшигчид өнгөрсөн 18 хоногийн хугацаанд өөр өөрсдийн хэмжээнд сурталчилгаагаа явуулж, олон нийтэд танигдахын тулд чармайж ажилласан. Өчигдөр шөнийн 00.00 цагаар сонгуулийн сурталчилгаа албан ёсоор дууссан байна. Тэгвэл "ММ" энэ удаагийн дугаартаа сонгогчдын мэдээлэлд нэмэр болох үүдээс сонгуулиа хэрхэн өгөх, саналын хуудасны зааварчилгаа, сонгогчийн үүрэг, эрх, энэ сарын 29-нд ямар ямар үйлчилгээ явуулах талаар нэгдсэн мэдээлэл хүргэхээр зорилоо. Монгол Улсын хэмжээнд байгаа тойрог, хэсгийн хороодын нэгдсэн мэдээллийг бүтэн оруулж чадахгүй учраас саналын хуудас хэрхэн бөглөх болон сонгууль өгөхөөр очиход танд ямар бичиг баримт хэрэгтэй талаар мэдээлэл бэлтгэлээ.*

### Мэдээллийн лавлах, цахим сайтуудаас санал өгөх байрны мэдээлэл аваарай

Нийслэлийн сонгогч та өөрийн санал өгөх байрны байршлыг http://cityelection.ulaanbaatar.mn/index.php/nith цахим хуудсаар авахаас гадна 1800-1617 утсаар үнэгүй лавлаж болох нь ээ. Мөн 1900-1950 зэрэг мэдээллийн лавлахууд ч иргэдийг мэдээллээр ханган ажиллаж байгаа юм байна. 2016 оны УИХ болон Нийслэлийн ИТХ-ын сонгуульд 924629 сонгогч есөн дүүргийн 397 санал авах байранд саналаа өгөх аж. Харин орон нутгийн иргэд болон нийслэлийн иргэд ч сонгуулийн талаарх нэгдсэн мэдээллийг СЕХ-ны албан ёсны вэб хуудаснаас гадна сонгуулийн бүх мэдээллийг нэг дор багтаасан http://songogch.songuuli.gov.mn сайтаас мэдээлэл авч болох аж. Хуулийн дагуу саналын хуудсыг санал авах байруудад тараасан бөгөөд байр тус бүрт нэг ахлах зохион байгуулагч, зохион байгуулагчид, иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгч, мэдээллийн технологийн даамал, цагдаагийн албан хаагч ажиллах юм. Мөн санал авах байр бүрт ажиглагч байх бөгөөд санал авах 397 байрны дотор болон гадна хяналтын камер ажиллах юм байна.

### Иргэн саналаа өгөхдөө иргэний үнэмлэхтэйгээ очно

Сонгууль өгөх цаг өглөө 07.00 цагаас эхлэх бөгөөд 22.00 цаг хүртэл үргэлжилнэ. Мөн энэ өдөр бүх нийтийн амралтын өдөр учраас томоохон зах, худалдааны төв ажиллахгүй. Мөн төрийн бүх байгууллагууд энэ өдөр амрах учиртай. Иргэн та санал өгөхөөр очихдоо иргэний үнэмлэхээ заавал авч очих нь ээ. Учир нь санал авах байранд очоод хурууны хээгээ даран өөрийн иргэний бүртгэлийн мэдээллийн улсын сан дахь сонгогчийн бүртгэл, сонгогчийн нэрийн жагсаалтын цахим хубилбартай таарч байгаа эсэхээ тулган шалгуулна. Хурууны хээг танихгүй байгаа тохиолдолд иргэний үнэмлэхээ үзүүлэн сонгогчийн бүртгэлд байгаагаа баталгаажуулах юм. Мөн сонгуулийн Хэсгийн хороодоос тараасан сонгогчийн үнэмлэхийг авч очих шаардлагагүй аж. Энэ өдөр бүх машин замын хөдөлгөөнд оролцох бөгөөд дугаарын хязгаарлалт үйлчлэхгүй. Үүнтэй холбогдуулан замын хөдөлгөөний ачаалал нэмэгдэж болзошгүй учраас ар иргэддээ аль болох нийтийн тээврийн хэрэгслээр үйлчлүүлэхийг ЗЦГ-аас уриаллаа. Мөн энэ өдөр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүднээс архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоод байгаа юм. Санал авах өдөр ажиллаж байгаа сонгогчид тухайн байгууллагын захиргаа чөлөө олгож, түүнийг санал өгөх боломжоор хангах үүрэгтэй.

**САНАЛ ТЭМДЭГЛЭХ ЗААВАР**

1. Улсын Их Хурлын сонгуулийн тойрогт нэр дэвшигчдийн дотроос өөрийн сонгохыг хүссэн **1** нэр дэвшигчийн нэрийн өмнөх зууван дугуйг дүүргэн будаж /⬬ / саналаа тэмдэглэнэ.

2. Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тойрогт нэр дэвшигчийн дотроос өөрийн сонгохыг хүссэн .... нэр дэвшигчийн нэрийн өмнөх зууван дугуйг дүүргэн будаж /⬬/ саналаа тэмдэглэнэ.

**СОНГОГЧ ТА**

- Саналаа тэмдэглэхдээ алдаа гарган буруу тэмдэглэл хийсэн бол САНАЛЫН ХУУДАС ДАХИН НЭГ УДАА АВЧ БОЛНО.
- Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тойрогт ногдсон мандатын тооноос илүү нэр дэвшигчийн төлөө санал өгвөл Таны санал хүчингүй болохыг АНХААРНА УУ!

---

*ЭНЭ ХЭСГИЙГ ЗӨВХӨН АНХААРАЛДАА АВАХ!!! ХЭВЛЭХГҮЙ*

*Жич: .... - Аймаг, нийслэлийн ИТХ-ын тойргийн мандатын тоог сонгуулийн тойрог тус бүрийн хэсэгт нь ялгавартай бичиж санал авах байрны бүхээг бүрийн дотор талд байрлуулаарай.*

### Өнөөдөр зөөврийн хайрцгаар санал авна

Сонгогч та саналаа зөөврийн битүүмжилсэн хайрцгаар эсхүл санал авах байранд өөрийн биеэр өгөх боломжтой. Хуульд заасны дагуу цөөн тооны иргэд л зөөврийн саналын хайрцгаар саналаа өгөх боломжтой юм. Өнөөдөр 09.00-20.00 цагийн хооронд зөөврийн хайрцгаар санал авна. Тодруулбал,

- Эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд өөрийн биеэр хүрэлцэн ирж чадахгүй;
- Нийтийн дайчилгаанд хамрагдан ажиллаж байгаа;
- Захиргааны зөрчлийн улмаас баривчлагдсан, албадан саатуулагдсан, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан;
- Байцаан шийтгэх албадлагын арга хэмжээний улмаас баривчлагдсан, цагдан хоригдсон
- Санал авах ажиллагааг зохион байгуулж байгаа сонгуулийн байгууллагын ажилтан, цагдаа, иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгч, мэдээллийн технологийн даамал

Санал авах байр зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчийн хүсэлт, магадлагаа, тодорхойлолтыг хүлээн авч тухайн хэсгийн сонгогч мөн эсэхийг шалгаж зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчдын нэрсийг гаргаж, санал авах чиглэл, хуваарийг гарган сонгогчийн саналыг тухайн санал авах байрын хоёроос доошгүй төлөөлөл гишүүн оршин байгаа газарт нь очиж авна. Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчдын нэрийн жагсаалтад ороогүй сонгогчийн саналыг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар авахыг хориглоно.

### Сонгогч Та саналаа хэрхэн өгөх вэ

УИХ-ын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийг хамт явуулж байгаа тул сонгуулийн саналын хуудсыг нэг хуудас дээр хэвлэх бөгөөд энэ тохиолдолд тухайн сонгууль тус бүрийн саналын хуудсыг бие даасан байдлаар ойлгоно. Сонгогч та саналын хуудас авч, санал бэлтгэх бүхээгт саналаа нууцаар гаргах бөгөөд саналын хуудсанд саналаа тэмдэглэхдээ холбогдох зааврын дагуу тэмдэглэгээг хийнэ. Санал бэлтгэх бүхээгт тухайн сонгогчоос өөр хүн байхыг хориглодог. Сонгогч нь нэр дэвшигчдийн дотроос өөрийн сонгосон нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугаарыг сонгож зааврын дагуу дүрсийг дүүргэн будсан тэмдэглэлээг хийнэ. Сонгогч дээр дурьдсаны дагуу саналаа тэмдэглэсний дараа саналын хуудсыг санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийнэ. Сонгогч санал өгөхдөө алдаа гаргаж, саналын хуудсанд буруу тэмдэглэл хийсэн бол саналын хуудсаа санал тоолох төхөөрөмж/ саналын хайрцаг/-д хийхээс өмнө энэ тухайгаа мэдэгдэж, алдаатай хуудсыг шалгуулан хураалгаж, дахин нэг удаа саналын хуудас авч, саналаа гаргах боломжийг хуулиар олгожээ. Бие эрхтний согог, эрүүл мэндийн байдал, боловсролын түвшингээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогч өөрийн итгэмжилсэн сонгуулийн эрх бүхий иргэний туслалцаатайгаар санал өгч болдог. Сонгуулийн байгууллагын ажилтан, албан тушаалтан, ажиглагч нь итгэмжлэгдсэн хүн байж болохгүй аж. Сонгуулийн санал өгөх загвар хуудас болон сонгууль өгөхдөө юуг анхаарах талаар дэлгэрэнгүй танилцуулгыг зургаар үзүүллээ.

### Сонгогчид хүлээлгэх хариуцлага

Шинээр батлагдсан Сонгуулийн тухай хуульд орсон онцлог зохицуулалтуудын нэг нь сонгогчид хариуцлага хүлээлгэх үндэслэлийг тодорхойлсон явдал юм. Тухайлбал, сонгогчид дор дурьдсан үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хуулиар хориглосон байна. Үүнд:

- Тухайн санал авах байранд саналаа өгөх эрхгүй гэдгээ мэдсээр байж санал өгөх,
- Өөр хүний бичиг баримт, эсхүл хуурамч бичиг баримт ашиглах зэргээр санал өгөх, санал өгөхийг оролдох;
- Тухайн санал авах байрнаас олгосноос өөр саналын хуудсыг санал өгөхөд ашиглах,
- Санал авах байранд гаднаас саналын хуудас авч орох, санал авах байрнаас саналын хуудас авч гарах;
- Саналын хуудаст тэмдэглэсэн саналаа болон бусад сонгогчийн саналыг баримтжуулан зураг авах, дүрс бичлэг хийх зэрэг үйлдэл хийх;
- Саналын хуудаст хийсэн тэмдэглэгээг бусдад харуулах;
- Аль нэг нэр дэвшигчийн төлөө санал өгөх, эсхүл өгөхгүй байхаар амлалт авах, мөнгө, эд зүйл шаардах, авах.

Дээр дурьдсаныг зөрчсөн иргэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 14 хоногийн хугацаагаар баривчлах захиргааны шийтгэл ногдуулахаар хуульчилжээ.



# ТҮҮХЭНД

## БАЙГААГҮЙ ОЛОН ТАМИРЧИН РИО-Г ДАЙЛААР МОРДОНО

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Энэ удаагийн Олимпийн наадамд оролцох хамгийн олон эрхийг жүдогийнхон авсан. Эрэгтэй долоо, эмэгтэй зургаан жин буюу 13 жинд Олимпийн наадамд оролцохоор болоод байгаа юм. Эмэгтэйчүүдээс +78 кг-д Монголыг дэлхийд төлөөлж байгаа О.Жавзмаа хараахан эрхийн оноогоо гүйцээж чадсангүй. Гэхдээ л Монголын жүдочид түүхэндээ анх удаа бараг л бүтэн багаараа Олимпийн наадамд оролцохоор боллоо. Эрэгтэй баг бүр бүтэн багаараа оролцож байна. Энэ бол жүдогийн их гүрнүүдтэй өрсөлдөхүйц амжилт. Мөн чөлөөтийн баг тамирчид 10 эрх авсан. Гэвч нэг хүн эрхээ хураалгасныг дээр дурьдсан. Тэгвэл эрэгтэй баг бүтэн багаараа Рио-2016 Олимпийн наадамд оролцохоор болоод байна. Энэ бол түүхэн амжилт. Хамгийн сүүлд 1992 онд манай эрэгтэй чөлөөтийн баг бүрэн бүрэлдэхүүнээрээ Олимпийн наадамд оролцож байж. Түүнээс хойш 24 жилийн дараа ийн зургаан тамирчин Рио-д өрсөлдөх нь. Дээрээс нь эмэгтэйчүүд гурван эрх авсан байгаа. Энд дурьдахгүй байж боломгүй амжилтыг манай боксын тамирчид гаргалаа. Түүхэндээ боксын тамирчид таван эрх авч байсан юм билээ. Тэгвэл энэ удаад зургаан эрх авч, Рио-г зорихоор болоод байна. Хамгийн сүүлд хоёр тамирчин эрхээ авснаар ийн түүхэн амжилтыг үзүүлж чадлаа. Монголын спорт үнэхээр илт хөгжиж байна. Хэдхэн жилийн өмнө манай өмнөө барих жүдо, чөлөөт, бокс, буудлагын төрөлд хэдэн тамирчин Олимпийн наадамд оролцдог байлаа даа. Нийлээд л 10 гаруйхан хүн л өрсөлдөнө. Бусад төрлөөс оролцох тамирчин ч байсангүй. Гэтэл өнөөдөр зөвхөн жүдогоос л 13 тамирчин Олимпийн наадамд зодоглох гэж байна шүү дээ. Энэ чинь улс орон хөгжиж, төр засаг, спортод элэгтэй хүмүүс мөнгө төгрөгөө харамгүй зарцуулж байгаагийн ач тус. Цаашлаад топ дөрвөн спортын төрлөөс гадна хөнгөн атлетикийн тамирчид маань цахиур хагалж эхэллээ. Тэр дундаа марафон марафон гүйлтийнхэн дөрвийн дөрвөн эрх авчихлаа. Энэ бол гайхалтай амжилт. Мөн таеквондогоор түүхэндээ анх удаа Олимпийн эрх өөрийн чадлаар авлаа, манай тамирчин. Байт харвааныхан маань ч дутахгүй нэг эрхтэй болсон. Хүндийн өргөлтөөс ч нэг эрх зулгаачихлаа. Энд зөвхөн Олимпийн наадмын эрх авсан тамирчдыг л дурьдаж байна. Паралимпийн эрх авсан тамирчдаа нэмээд тоолбол Рио-д манай 40 гаруй тамирчин очих нь тодорхой байна. Энэ бол түүхэн амжилт. Ийм амжилтаар бахархахгүй байхын арга алга.

### Монголын тамирчид хоёр алтан медаль авах уу

Олон тамирчин Олимпийн наадамд оролцох эрхээ авсантай холбоотойгоор хэдэн медаль авах вэ гэдэг таамаг дагаж байгаа. Манай тамирчид 2008 онд Бээжингийн Олимпийн наадмаас хоёр алт, хоёр мөнгө авч байсан. Харин Лондонгийн олимпийн наадмаас хоёр мөнгө, гурван хүрэл медаль авч байлаа. Энэ хоёр Олимпийн наадамд манай улс 30 хүрэхгүй тамирчнаа оролцуулж байсан юм. Тэгвэл одоо түүнээс даруй 10-аар олон тамирчнаа оролцуулахаар болчихоод байна. Тэр дундаа жүдо, боксынхон өргөн бүрэлдэхүүнтэй оролцоно. Боксынхон гэхэд Бээжингээс 2008 онд алт, мөнгөн медаль хүртэж байлаа. Харин 2012 онд Лондонгоос мөнгө, хүрэл медаль хүртсэн. Ямар ч байсан сүүлийн хоёр Олимпийн наадмаас хоёр медаль авсан буухиагаа тасалсангүй. Тэгвэл энэ удаад түүхэнд байгаагүй олон хүний бүрэлдэхүүнтэй оролцож байгаа учраас ядаж л хоёр медалийн буухиагаа таслахгүй байх болов уу. Дээрээс нь жүдогийнхон үеийн үед найдлага алдаж үзээгүй. 2000 онд хоосон хоцорсныг эс тооцвол. 2008 онд Н.Түвшинбаяр аварга алт авсан. 2012 онд Н.Түвшинбаяр мөнгө, С.Ням-Очир хүрэл медаль дээр бууж байлаа. Тэгвэл энэ удаад бүхэл бүтэн 13 тамирчин оролцоно. Тэр дундаа эрэгтэй баг бүтэн багаараа оролцох юм. Монголын жүдочдын ихэнх нь жиндээ нэлээд амжилттай яваа. Эрэгтэй 60 кг-д Ц.Цогтбаатарт найдаж болно. Медаль дээр буучихсан байхад гайхаад байхааргүй чадвартай тамирчин. Бага хий гаргаж барилдвал хангалттай чадвар бий. 66 кг-д барилдах Д.Төмөрхүлэг Олимпийн наадамд амжилт гаргах цаг, тохироо нь бүрдчихсэн тамирчин.Түрүүлчихсэнбайхыг ч үгүйсгэх аргагүй. 73 кг-д Г.Одбаярт, 90-д Л.Отгонбаатарт, -100-д Н.Түвшинбаяр аваргад найдлага хүлээлгэх гээд байгаа. Эмэгтэйчүүдээс 48 кг-д М.Уранцэцэг, 57-д Д.Сумъяа, 63-т Ц.Мөнхзаяа нар найдаж болохоор байгаа. Чөлөөтөөс С.Батцэцэг гавьяатыг финалдах болов уу гэж бүх хүн харж байна. Дээрээс нь эрхээ авсан нөгөө хоёр эмэгтэй тамирчиндаа ч найдаж болно. Харин хэн Рио руу явах вэ гэдгээс их зүйл шалтгаалах байх. Эрэгтэйчүүдийн хувьд найдах тамирчин олон байна. Э.Бэхбаяр, Г.Мандахнаран, П.Өнөрбат, Ж.Чулуунбат, О.Үйтүмэн, Д.Хүдэрбулга гээд бүгдэд нь найдлага тавьж болно. Эрэгтэй баг ийм л хүчирхэг, чадвартай, авьяаслаг тамирчдаас бүрдэж байгаа юм. Мэдээж буудлагынхандаа бас найдлага тавих учиртай.

Энд нэг зүйлийг дурьдахад, улс орнуудын спортын чансааг тооцоолж, олимпод медаль хүртэх боломжийг нь тодорхойлдог "Infostrada" цахим хуудас 2016 оны эхний чансаагаа гаргасан. Энэхүү чансаанд Монгол Улсын багийг Рио де Жанейрогийн олимпод 10 медаль хүртэж, багийн дүнгээр 33 дугаар байр эзэлнэ хэмээн таамагласан байна. Спортын төрөл бүрээ арван хуруу шигээ мэддэг 100 гаруй шинжээч, спортын 250 гаруй төрөлд судалгаа явуулдаг. Дэлхий даяар болж буй уралдаан тэмцээний дүн, тэр ч байтугай хэн, хэнтэй хэрхэн өрсөлдсөн зэргийг харгалзан үзэж, сүүлийн 15 жилийн үзүүлэлтийг судалгаандаа ашигладаг учраас эдний таамаглал биелэх магадлал өндөр байдаг. 2012 оны Лондоны олимпийн наадмын медалийн жагсаалтыг 80 хувийн магадлалтай гаргасан нь эдний судалгааны чанарын нэг илэрхийлэл юм.

Тэдний судлаачид Монголын багийн хоёр алтан медалийн эзнээр жүдо бөхийн эмэгтэйчүүдийн 57 кг-д өрсөлдөх Д.Сумъяа, Чөлөөт бөхийн 63 кг-д оролцох С.Батцэцэг нарыг нэр цохсон. Д.Сумъяа сүүлийн үед том тэмцээнд босоо байгаа. Дэлхийн мастерууудын тэмцээнд гурав дараалж түрүүлсэн. 57 кг-д түүнтэй өрсөлдөх цөөхөн жүдоч байгаа юм. Алдаа гаргачихгүй л бол түрүүлнэ. С.Батцэцэг гавьяат дэлхийн аваргаар бүх өрсөлдөгчөө илт давуу ялсан учраас түүнийг түрүүлэх хүний тоонд багтаахгүй гээд ч яах билээ. Мөн М.Уранцэцэг гавьяат, П.Өнөрбат нарыг финалдана гэж энэхүү сайт таамагласан байгаа юм.

Тэгвэл Нэгдсэн улсын өдөр тутмын чөлөөт хэвлэл "USA Today" сонины спортын мэргэжилтнүүд Олимпийн наадам бүрийн өмнө медаль хүртэх тамирчдын тухай өөрсдийн таамгийг гаргадаг. Бүх спортын төрөлд медаль хүртэх тамирчдын нэрийг өөрсдийн хувилбараар гаргадаг учир олон улсын сэтгүүлчид тэдний мэдээллийг хүлээж суудаг юм. "USA Today" сонины спортын мэргэжилтнүүд 2008 оны Бээжингийн зуны Олимпийн наадмаас Монгол Улс алтан медаль авна гэж таамаглаж байсан "мэргэн харваачид". Мөн 2012 оны Лондонгийн наадмаас Монголын тамирчид нэг алт, нэг мөнгө, нэг хүрэл, нийтдээ гурван медаль авна гэж бичиж байлаа. Тухайн үед жүдо бөхийн эрэгтэйчүүдийн 66 кг-д дэлхийн аварга, олимп, ДАШТ-ий хүрэл медальт, Хөдөлмөрийн баатар Х.Цагаанбаатарыг түрүүлнэ гэж тооцож байлаа. Харин эмэгтэйчүүдийн 52 кг-д дэлхийн аваргын хүрэл медальт, гавьяат тамирчин М.Бундмааг Японы Юүка Нишидатай финалдаж, мөнгөн медаль хүртэнэ гэж "прогноз"-джээ. Мөн Хөдөлмөрийн баатар, дэлхийн аварга, олимпийн мөнгөн медальт боксчин П.Сэрдамба хүрэл дээр бууна гэж таамаглаж байв "USA Today" сониноос гаргасан Олимпийн медаль хүртэх тамирчдын 63.9 хувь тухайн наадмаас ямар нэгэн медаль авч байсан учир улс орнуудын спортын холбоод тэднийг ямар таамаг гаргахыг хүлээх болсон билээ. Мөн "USA Today" сонины зүгээс бөхийн төрлүүдэд хэн нь 2016 онд медальд хүрэх вэ гэсэн судалгааг хийгээд эхэлжээ. Тэдний таамаглаж байгаагаар Монголын жүдочид хоёр медаль авна гэсэн бол чөлөөтийнхөн нэг хүрэлтэй нутаг буцна гэжээ. Түүнчлэн буудлагын спортын төрөлд О.Гүндэгмааг доод тал нь шигшээ наймд үлдэнэ гэсэн байна. Харин нийт медалийн тоогоор АНУ, ОХУ, БНХАУ, Герман, Англи, Австрали, Япон, Франц, БНСУ, Италийн баг эхний аравт орно гэдгийг урьдчилан таамаглаад байгаа юм.





Дугаарын 60 мөр

## Сонгуулиа өгцгөөе, залуус аа

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Уг нь бид өөрсдөө л зөв хүнээ сонгож, дараа нь түүнээсээ хариуцлага нэхдэг болмоор байна. Ямар ард түмэн байна, тийм төр байдаг гэдэг. Бид сонгуулиа өгөхгүй залхуурч, эсвэл хэн нэгний ухуулсан ухуулгад урхидуулж хэвтэж байх зуур өөр хэсэг нь төрд гарах ёсгүй хүмүүсийг сонгож байна. Өөрөөр хэлбэл, улстөрчдийн гар хөл болсон нөхдүүд, цүнх баригчид, мөнгө авсан хэсэг бүлэг гээд өөрийн эрх ашгийн төлөө л санал өгдөг хүмүүсийн эргэн тойрон дахь нь төрд гарчихаж байгаа юм. Яг үнэндээ сонгуулиар миний, чиний, бидний, залуу хүн бүрийн санал дутдаг юм шүү дээ. Магадгүй та нэг нам дэмждэг байж болно. Гэтэл сонгуулиа өгөөгүйгээс болоод тэр намын чинь нэр дэвшигч ялалт байгуулахгүй бол яах билээ. Нэг нэр дэвшигч нь ялалт байгуулж чадаагүйгээс болж тухайн нам, эвсэл төр барьж чадалгүй, бодлогоо хэрэгжүүлж чадахгүй болбол яана. Эсвэл та хүнийг нь харж, төрд илгээх ёстой гэж бодож байсан ч саналаа өгөхгүй бол ялалт байгуулахгүй ч байж мэднэ. Та төрд шинэ, залуу хүн хэрэгтэй. Төрд салхи оруулах цаг болсон гэж боддог байж болно. Тэгвэл тэр бодлоо үр дүнд хүргэхийн тулд шинэ хүнээ сонгох ёстой биз дээ. Өнөөдөр бид Монгол Улсыг өөрчлөх хэрэгтэй гэдэг дээр бүгд санал нэгдэж байгаа. Ард түмний амьдрал сайхан болж, улс орон хөгжихийг харахын хүслэн болж буй байх. Тэгсэн мөртлөө өөрчлөлтийг өөрөөсөө эхэлж, зөв сонголтоо яагаад хийхгүй байгаа юм. Улс орон хэцүүдлээ, тэр нь ч тэглээ, энэ нь ч ингэлээ гээд л хий хоосон муулаад байдаг. Тэгвэл муу санагдсанаа өөрчлөхийн төлөө, сайн гэснээ дэмжихийн тулд саналаа идэвхтэй өгцгөөе. Анх Монгол Улсад сонгууль болж байсан 1992 онд сонгуулийн ирц 95 хувьтай байж. Гэтэл 2012 оны сонгуулиар ирц дөнгөж 65 хувьтай байж. Энэ жил үүнээс ч бага байвал яах вэ. Сонгууль дахин явуулах шаардлага гарвал яана. Иргэд бидний татварын мөнгө үргүй урсана л гэсэн үг. Энэ хэний буруу байх вэ, хойргошиж, идэвхгүй байсан залуучуудын л буруу шүү дээ. Яг үнэндээ сүүлийн жилүүдэд нас тогтсон хүмүүс л сонгуульдаа идэвхтэй оролцож байгаа. Дээр дурьдсан 65 хувийн ирцийн бараг 70-75 хувь нь настайчууд байгаа гэдэгт эргэлзэх юм байхгүй. Өөр сонголт хийж, өөрөө сэтгэх ёстой залуучууд бид зүгээр л гэртээ хэвтээд, төр барих эрхээ ч эдлэхгүй л байгаа шүү дээ. Тэгээд нэгж өгнө гэхээр очдог байх жишээтэй. Ийм хариуцлагагүй байдлаа өөрчлөх цаг болсон. Бид хүссэн сайхан ирээдүйгээ авч ирэхийг хүсч байгаа л сонголтоо зөв хийж, сонгуульдаа идэвхтэй оролцох цаг болсон шүү дээ.

## ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

# НААДМЫН ГОЁЛОО ЗЭХЭЖ АМЖСАН УУ



**–Энэ жил энгийн “универсиал” дээл модонд орж, завсрын өнгө давамгайлах нь–**

*Харин материалын хувьд үс, арьс, капрон, шифон, 2-3 төрлийн нимгэн торгонууд оржээ. Ингээд тус салоны туслах загвар зохион бүтээгч Б.Номинтой ярилцлаа.*

**-Энэ жил ямар загварын дээлийг хүмүүс илүү сонирхож байна вэ?**

-Энэ жил хүмүүс ихэвчлэн хослол хийлгэж байна. Тухайлбал, үндэсний хэв загварыг шингээсэн юбка, цамцны хослолыг захиалгаар хийлгэж байна. Манай “Торго” салоны загварын каталогид энгийн загвартай, завсрын өнгөтэй дээлнүүд зонхилж байгаа. Чимэглэлийн хувьд соно, эсгий чимэглэл, гуулин зах, металл төмөр чимэглэлүүд түлхүү орсон. Ер нь классик загвар голчилж байна. Мөн хэдэн ч төрлөөр өмсч болдог универсиал дээлнүүдийг хүмүүс их сонирхох болсон. Ханцуйг нь аваад плать болгож өмсдөг ч юм уу. Тийм загварын дээл үйлчлүүлэгчдийн маань сэтгэлд нийцэж байгаа учраас манайх загварын каталогидоо ч багтаасан.

**-Наадам зун болдог. Тиймээс улирлын уур амьсгалаас шалтгаалан дээлний материалын хувьд ч гэсэн онцлогтой байгаа болов уу. Материалын талаар мэдээлэл өгөхгүй юу?**

-Тийм шүү. Наадмаар улирлаас шалтгаалаад их халуун байдаг шүү дээ. Хүмүүс ихэвчлэн гадуур явдаг учраас халууцах асуудал гардаг. Тиймээс дээлний материалын хувьд ч гэсэн нимгэн болсон. Бид энэ жил шинэ материалууд авч ирлээ. Тухайлбал, сильк, торон мөн цамцны материалыг авч ирсэн.

**-Хаанаас материалаа авч ирдэг вэ?**

-Манай компани нь Хятад болон Тайланд улсаас цэвэр 100 хувийн хүр хорхойн шүлсээр нэхсэн дээд чанарын торгыг оруулж ирдэг юм. Тэр торгоороо монгол үндэстэн ястны уламжлалт болон орчин үеийн хэв загварын хувцсыг хэрэглэгчийн хүссэн хийц загвараар чанарын өндөр түвшинд урладаг.

**-Өвөл, хаврын загварт урт куртка зонхилсон. Үндэсний загварын дээлэнд урт загвар орж байна уу?**

-Ер нь манай үндэсний энгийн дээл урт байдаг. Сүүлийн үед загвар, хэв маяг нь өөрчлөгдөж богино болсон. Харин энэ өвөл, хаврын загварт урт хувцаснууд зонхиллоо. Үүнийг дагаад охид бүсгүйчүүд ч гэсэн урт загварын хувцас сонирхож байна. Монгол загварын дээл ч гэсэн урт байгаа.

**-Сүүлийн үед хүмүүс хос дээл их өмсөх болсон. Энэ жил хос дээл захиалж байна уу?**

-Тийм. Хос дээл их захиалж байгаа. Гэхдээ аав нь хүүтэйгээ, ээж нь охинтойгоо гэх мэтчилэн хослох нь их байна.

**-Эрэгтэй дээлний загвар хэрхэн өөрчлөгдсөн бэ. Энэ жил ямар загварын дээл өмсвөл зүгээр вэ?**

-Эрэгтэйчүүд сүүлийн үед дээл гэхээсээ илүү сорочкон загвартай монгол цамц өмсдөг болсон. Нимгэн, хөдөлгөөнд саад болохгүй үндэсний хэв загварыг шингээсэн цамц өмсч байна.

**-Үнийн хувьд?**

-Тухайн дээлний загвар, чимэглэлээс хамаарч янз бүр л дээ. Ер нь хамгийн доод талдаа 450 мянган төгрөгөөр оёдог. Дундаж нь гэвэл 600-700 мянган төгрөг. Харин хамгийн үнэтэй дээл нь 1.4-1.5 саяд хүрч байна.

**-Захиалга өгвөл хэд хоногт гарах вэ?**

-7-10 хоногт гарна. Хэрвээ яаралтай захиалга өгвөл тав хоногт гарах боломжтой.

## Тэрбээр ийн ярив

“Торго” салон энэ жилийн загвартаа хэд хэдэн шинэлэг зүйлийг хийж өгчээ. Тодруулбал, оёдлын технологидоо зүү ороох, зээг дарах, утас дарах гэх мэтчилэн Монголын уламжлалт оёдлын технологиудыг ашиглахыг зорьсон байв. Мөн монгол дархны уран нарийн хийцийг харуулсан жижиг деталуудыг олноор нь ашиглажээ. Үндэсний загварт уламжлалт оёдлын технологи, дархны уран хийцийг тусгаж өгсөн нь монгол уламжлалыг үндэсний хувцаст авч үлдэх зорилготой байгаагаа ч тус салоны туслах дизайнер Б.Номин тайлбарласан юм. Түүний хэлснээр тус салоны хувцас үндэсний хэв загварыг бүрэн шингээжээ. Энэ зуны загвартаа монгол арсланг хүртэл урласан харагдсан. Өнгө өнгийн цэцэг, монгол хээ, соно, галбингааг зөвхөн “Торго” салоны дээлнүүдээс л харах боломжтой аж. “Торго” салоныг зорих хүмүүс ч тасрахгүй юм. Ирсэн хүн бүр тус салоны каталогиос өөрийн хүссэн загварыг сонгож харагдсан. Мөн дизайнер нь тухайн үйлчлүүлэгчтэйгээ ярилцаж, түүнд таарсан цорын ганц загварыг ч урлаж өгдөг юм билээ.

## Гар урлалаар чимэглэсэн энгийн дээл энэ жилийн наадмыг өнгөлнө



Бид 16 жилийн туршлага бүхий үндэсний салоноос гарч, сүүлийн үед охид, залуусын үйлчлүүлэх дуртай болсон “Үргэлж залуу” урланг зорьсон юм. Тус урлан нь анх 2014 онд байгуулагдсан бөгөөд өдөр тутмын болон үндэсний дээл, хувцас урлаж, хүмүүст хүргэдэг байна. “Үргэлж залуу” урлангийн энэ жил дизайнерууд энгийн, хаана ч өмсч болох дээлийг онцолж байгаа аж. Энэ талаар тус урлангийн дизайнер Аюу Нару “Манай урлан “Үргэлж залуу” гэж брэндтэй. Энэ жилийн наадмаар монгол хүний биеийн онцлогт тохирсон уламжлалт хэв маягийг шингээсэн монгол цамцыг үйлдвэрлэж байгаа. Уг цамц маань монгол хүний биеийн дундаж стандарт хэмжээст үндэслэн S, M, L гэсэн гурван төрлийн хэмжээтэй. Материалын хувьд уламжлалт торго болон даавуун материалтай. Ер нь манай хувцасны нэг давуу тал нь гараар чимэглэдэг. Hand made буюу гар урлал тухайн загвар зохион бүтээгчээс их хөдөлмөр шаарддаг” гэсэн юм. “Үргэлж залуу” урлан мөн л Н, А хэлбэрийн хүний биед эвтэй, хөдөлгөөнд саад учруулахгүй загваруудыг санал болгож байлаа. Мөн байгалийн өнгө зонхилох бөгөөд гоёмсог шигтгээ, шүр, сувдан чимэглэлүүд байх гэнэ. Түүнчлэн тод, алаг өнгийн дээлний зах, бүсэлхий, товч шилбэ, эмжээртэй байх аж. Ингэснээр шинэ загварын өнгө төрх илүү гарч ирнэ гэдгийг тус урлангийн загвар зохион бүтээгч  Аюу Нару онцолж байв. Хамгийн гол нь нэг удаад өмсөөд орхих биш дараа нь өмсөж болохуйц дээлийг хүмүүст санал болгож байгаа ажээ.

...“Үргэлж залуу” урлан мөн л Н, А хэлбэрийн хүний биед эвтэй, хөдөлгөөнд саад учруулахгүй загваруудыг санал болгож байлаа. Мөн байгалийн өнгө зонхилох бөгөөд гоёмсог шигтгээ, шүр, сувдан чимэглэлүүд байх гэнэ. Түүнчлэн тод, алаг өнгийн дээлний зах, бүсэлхий, товч шилбэ, эмжээртэй байх аж. Ингэснээр шинэ загварын өнгө төрх илүү гарч ирнэ гэдгийг тус урлангийн загвар зохион бүтээгч Аюу Нару онцолж байв. Хамгийн гол нь нэг удаад өмсөөд орхих биш дараа нь өмсөж болохуйц дээлийг хүмүүст санал болгож байгаа ажээ...



## Хэрэглэгчид “универсал” дээлийг сонирхох болжээ



Манай сурвалжлах хэсгийн дараагийн очсон газар бол “Уран хатгац” болон “Алтан утас” компани. “Уран хатгац” компанийн хувьд өөрийн нэрийн “NG” брэндтэй юм билээ. Уг брэнд монгол үндэсний өв соёлын томоохон илэрхийлэл хувцаслах соёлыг бусдад түгээн дэлгэрүүлэх зорилготой ажээ. Байгуулагдаад гурван жил болсон ч аль хэдийнэ өөрсдийн хэрэглэгчидтэй болж чадсан байна. Энэ тухай тус компанийн гүйцэтгэх захирал Ө.Оюун “Өмнөх жилүүдийг ажиглаж байхад энэ жилийн хувьд тод өнгийн, нимгэн капронон, цоохор материалууд эрэлттэй байна. Нимгэн капронон материалыг угааж, цэвэрлэхэд амархан, биед хөнгөхөн байдаг. Манайх солонгос даавуун материалуудаар хувцсаа урладаг. Гэхдээ даашинзны юбка болон ханцуй хэсгийг торгоор хийдэг. Яагаад гэвэл дан ганц торгоор урласан хувцас өдөр тутам хэрэглэхэд тохиромжгүй, биеийг тавгүйтүүлж, хатгах, загатнах зэрэг зовиур үүсгэдэг. Тиймээс хэрэглэгчдийн саналыг харгалзан үзэж ийнхүү хийдэг. Бид хэрэглээ талаас нь анхаардаг.

# ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА












Тухайлбал, нэг дээлийг сонгон авъя. Харахад үргэлж мэт боловч юбка цамц гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Ганцхан өргөн бүсээрээ зааглагдана. Цамц нь өөрөө бас нарийн бүстэй. Тус тусад нь тохирох, зохих зүйл дээрээ хослуулж ердийн үедээ салгаж өмсч болно. Энэ бол чөлөөт загвар учраас биед эвтэйхэн, тааламжтай байдлыг бүрдүүлнэ. Үүгээрээ хүмүүсийн хэрэгцээн дээр тулгуурлан урладаг гэдгээ харуулж байгаа" гэв. Харин "Алтан утас" компанийн хувьд дээлний материалын чанарыг онцолдог байна. Энэ талаар тус компанийн дизайнер Х.Мөнхцэцэг "Хими цэвэрлэгээгээр цэвэрлүүлэхэд манай торго асуудал гарахгүй, агшихгүй. Өнгөрсөн жил эрээн торгон оруулгатай, түжигнэж, бум бужигнасан "Нарантуул" захыг ч энэ удаа орхисонгүй. Тус захаар орж дээлний загвар болон үнийг сонирхлоо. Биднийг очих үед нар хэдийнэ дээш хөөрч "Нарантуул" худалдааны төв олны хөлд дарагдаж, худалдан авалт ид өрнөж байлаа. Монгол үндэсний их баяр наадам болох гэж байгааг ч хэлэх үү, наадмын гоёлоо зэхэх гэсэн хүмүүс "Нарантуул" захыг зорьж торго, дурдан, хээ хуар болсон чамин тансаг дээл хантаазнууд сонирхох аж. Бид юун түрүүнд энэ жилийн наадмын трэнд өнгийг сонирхохоор дээл худалдах хэсэгт очив. Тус тасаг руу ормогц л "Ямар дээл сонирхож байна, бөөний үнээр тохироод өгнө шүү" хэмээх худалдагч нарын дуу энд тэндгүй сонсогдож, хажуугаар өнгөрсөн хүн бүрийг дуудаж байлаа. Мөн ховор монгол наадамдаа хэнээс ч дутахгүй өнгө үзэмжтэй сайхан харагдахыг хэн хүнгүй хүсдэг. Тэр тусмаа хөдөө орон нутгаас наадмын гоёлоо авахаар ирсэн иргэд их хатуу шалгуур тавин худалдаж авдаг гэнэ. Тэд эмжээрийн нарийн бүдүүн, танаас, ухлаадас, хойд хормойны оруулга, хавалт, дээлний материалын чанар зэргийг маш нарийн харж, худалдан авалт хийдэг нь бужигнасан олны дотор аажуу тайван гэгч нь даавууны ширхэг бүрийг тэмтрэн зогсож байгааг харахад л илт байлаа. Энэ жилийн дээлний өнгө ерөнхийдөө завсарын болон улаан, ягаан, саатай цэнхэр эмэгтэй дээл, бараан хүрэн, усан цэнхэр өнгийн эрэгтэй дээл борлуулалт сайтай байгаа аж. Мөн өвдөгнөөс дээшээ оффис маягийн бариу загварын дээл хантаазуудыг охид бүсгүйчүүд сонгох нь





хонхон эсвэл найман нуглааст хормойтой гоёлын дээл трэнд болж байсан. Харин энэ жил өнгийн хувьд шаргал буюу бэйж /цайвар/ өнгө зонхилж байна. Загварын хувьд элдэв гоёлын гэхээс илүүтэй энгийн, жинхэнэ монгол өнгө шигтгэсэн, маш нимгэн материалтай, цул өнгийн, шулуун загвар захиалга ихтэй байгаа. Харин хүүхдийн дээлний хувьд жаахан өөр. Дан дээл биеийг нь барина. Тэрлэг нь халууцуулдаг. Иймээс монгол зах, энгэртэй хүүхдийн плать түлхүү захиалж байна" гэсэн юм. Үнийн хувьд "Уран хатгац" компанийн урласан дээл 80-220 мянган төгрөгийн хооронд бөгөөд улсын баяр наадмыг тохиолдуулан 15-20 хувийн хөнгөлөлт зарлажээ. Харин "Алтан утас" компани загварын дээлээ 320-600 мянган төгрөгөөр урлаж байсан.

## Загварын монгол дээл 75 мянгаас эхлэнэ

Манай сурвалжлах хэсэг түм өнгө дурдан хослон, хээ хуараар чимэглэсэн торгон, чисчүү, даавуун материалтай, дан болон давхар эмжээртэй янз бүрийн загварын дээлнүүд өлгөөтэй байв. Наймаачдын хэлж байгаагаар баяр наадам эхлэхээс нэгээс хоёр долоо хоногийн өмнө наадмын гоёлоо бэлтгэх хүмүүс олширч, өдөртөө нэг лангуунаас дунджаар таваас зургаан дээл борлогддог гэнэ. Харин энэ жилийн хувьд эдийн засгийн хямрал уу, иргэдийн монгол дээлээр гоёх хандлага багассаных уу хүмүүсийн худалдан авалт муу байгаа аж. Энд энгийн монгол дээл загвар хийц материалаасаа хамаарч 75-250 мянга төгрөг, чамин хээнцэр, загварын дээл хантааз 70-280 мянга, хос дээл 230-450, хос загварын дээл 450-750 мянга, хүүхдийн дээл 15-75 мянган төгрөгийн үнэтэй байна. Өнгөрсөн жилтэй харьцуулахад энэ жил дээлний үнэ ч хямд, борлуулалт ч муу байна хэмээн наймаачид бухимдаж байсан бол иргэд жил ирэх тусам дээлний үнэ нэмэгдэж, хийц муудаж байгааг хэлж байлаа. Дэлхийд



элбэг байгаа гэнэ. Түүнчлэн сонгуульд нэр дэвшиж буй эмэгтэйчүүд цэнхэр өнгийн дээлээр гоёж, цэнхэр өнгийг трэнд болгосон. Тэгвэл энэ хандлага энгийн ард иргэдийн дунд ч байна. "Би уг нь цэнхэр өнгийн дээл авмаар байна гэхдээ надад улаан дээл зохиж байна гэх юм" гээд дурамжхан улаан дээл өмсөөд толидон зогсох эмэгтэйг харахад, дөч эргэм насны намбалаг эмэгтэй байлаа. Түүний худалдагчтай ярих нь цэнхэр өнгийн дээл эмэгтэй хүнийг их төв, намбалаг царайтай харагдуулдаг. Хамгийн гол нь их гоё ихэмсэг, эмэгтэйлэг харагдуулдаг гэнэ. Энэ хандлага ерөнхийдөө 40-өөс дээш насны эмэгтэйчүүдийн дунд газар авч, энэ жилийн наадмаар цэнхэр дээл өмссөн намбалаг эмэгтэйчүүд олон харагдах бололтой.

## Халх дээл мoодноос гарч, загварын дээлний үнэ тэнгэрт хадав

Ийнхүү сонголт өргөнтэй монгол дээлний худалдаагаар цааш явж, худалдагч нартай ярилцав. Монгол дээлний худалдаа эрхлэгч Ш.Баттулга "Тэгш төрийн дээл гэгдэх монгол дээл нь хүний биеийг төв шулуун, тэгш намбатай харагдуулдаг.Тийнхүү монгол дээл нь нэг тийш дарж бүсэлдэг, ташуу болон дөрвөлжин энгэр, хоёр ташаа бүхий эх биетэй, дотор гадар энгэртэй байдаг. Монгол үндэсний уламжлалт дээл нь ганц хувцас төдийгүй нүүдэлчин монголчуудын бие, эрүүл мэндийн онцлог хийгээд цаг ууртай төгс зохицсон байдаг. Гэтэл сүүлийн жилүүдэд орчин цагийн загварын дээл гэгдэх энд тэндээ оноотой, өндөр мөртэй, биеийн ихэнх хэсэг ил гарсан сонин хийцтэй дээлнүүд их гарах болж. Эдгээр дээлнүүд нь харахад үзэмжтэй сайхан хэдий ч монгол үндэстний хувцас биш. Миний бодлоор урд зүгийн л хувцас шиг харагдаад байдаг юм. Үүнийг дагаад залуус ч чамин хээнцэр загварыг сонгож янз бүрийн загварын дээлний үнэ тэнгэрт хадан монгол үндэсний уламжлалаа хадгалж үлдэж байгаа халх дээлний эрэлт багасахын хэрээр үнэ ч хямдхан байгаад их сэтгэл дундуур байдаг. Хүмүүс нэг зүйлд хошуурахаараа бүгд хошуурдаг. Өнгөрсөн жилүүдэд "Хүннү" захтай дээл гэж хошуураад байсан. Одоо бол богино энд тэндээ нугалаатай өнгө өнгийн дээлийг сонирхох болж. Бид ч үүнд нь тааруулж дээл хувцсаа авчирдаг ч монгол хүнийхээ хувьд халх дээлээ монгол хүн бүр өмсөөсэй гэж хүсдэг. Тиймээс халх дээлээ 65-230 мянгын хооронд хямдхан зардаг ч хүмүүсийн худалдан авалт муу байна" хэмээн хуучилсан. Нээрээ ч дээл худалдан авахаар ирсэн хүмүүсийн талаас илүү хувь нь загварын дээл рүү нүдээ бэлчээж үнэтэйг нь гайхан зогсоно. Харахын заяа байхаас хазахын заяагүй гэгчээр өөрт таалагдсан гоё дээлээ авч өмсөхөд мөнгө дутаж, өөртөө байгаа мөнгөндөө тааруулан дээл худалдаж авч байгаа нэгэн ч бидэнтэй таарч байв. Энэ үеэр худалдан авалт хийхээр дээл өмсч үзэж байсан Н.Гэрэлмаа "Би уг нь тэр ягаан дээлийг авахыг их хүссэн. Даанч мөнгө маань дутчихлаа. Яг үнэндээ санхүүгийн хувьд жаахан хүндрэлтэй байна. Цалингаа аваад өдөр тутмын хэрэгцээндээ л зарцуулдаг. Өөр зүйлд хүрдэггүй. Харин саяхувцааныхаа мөнгөөр дээл худалдаж авахаар гарч ирлээ. Наадам ойртох тусам үнэтэй болдог болохоор хэрэндээ л эрт гарч ирсэн. Гэтэл бас л үнэтэй байна. Хэрэв хувцааныхаа мөнгийг бөөнд нь авсан бол бүр илүү гоё дээл авч өмсөөд, хоёр





гурван жилдээ гангарах байлаа" гэсэн юм. Ийнхүү худалдан авагчид ч нэмэгдэж, хүмүүсийн хөл хөдөлгөөн улам ихэсч, наадмын гоёлоо бэлтгэхээр ирсэн хүмүүс зөвхөн дээлний тасагт ч биш торго дурдангийн лангуун дээр зай завсаргүй шавж харагдсан. Ямартай ч энэ жилийн дээлэнд завсрын бэйж өнгө трэнд болж, энгийн үед ч өмсч болох, сул, нимгэн загвартай дээлнүүд моодонд орж байна. Түүнчлэн дизайнеруудын ур ухаан тэлэхийн хэрээр олон төрлөөр өмсч болдог дээлнүүд ч гарсан байх юм. Түүнийг дагаад "универсиал дээл" сонирхох хэрэглэгчдийн тоо ч өсчээ.

# ДЭЛХИЙ

## Хиллари Клинтон чансаагаараа тэргүүлж байна

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан нам болон Бүгд найрамдах намаас нэр дэвшигчдийг эцсийн байдлаар ирэх сард зарлах учиртай. Гэсэн ч, намуудаас хэн нэр дэвших нь хэдийнэ тодорхой болоод буй юм. Тодруулбал, Бүгд найрамдах намаас үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп өрсөлдөгчгүй болж тунаж үлдээд буй бол Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон Ардчилсан намаас нэр дэвших нь тодорхой болоод буй. Тэгвэл улс төрийн туршлага тэс ондоо хоёр нэр дэвшигчдийн чансааг тодорхойлох санал асуулгыг Вашингтон пост, ABC агентлаг энэ сарын 26-нд явуулсан байна. Уг санал асуулгаас үзэхэд, Хиллари Клинтон өрсөлдөгчөө хол хаяж, чансаагаараа тэргүүлсэн үзүүлэлттэй явна. Тус санал асуулгад оролцогсдын 51 хувь нь Хиллари Клинтоныг дараагийн Ерөнхийлөгч болно хэмээн дэмжсэн бол Бүгд найрамдах намын сахилгагүй тэрбумтан Доналд Трампыг 39 хувь нь дэмжсэн байх юм. Харин “Валл Стрип Журнал”, NBC news агентлагуудын хамтарсан судалгаагаар Хиллари Клинтоныг 46 хувь нь дэмжиж байсан бол 41 хувь нь Трампад саналаа өгсөн байжээ. Өнгөрсөн сарын сүүлчээр гэхэд сонгуулийн кампанит ажилдаа Хиллари Клинтон 42 сая ам.доллар зарцуулсан байсан Трамп 1.3 сая ам.долларыг зарцуулсан байв.

## Фольксваген АНУ-д 10.2 тэрбум ам.доллар төлнө

Германы авто машин үйлдвэрлэгч Фольксваген корпораци хууран мэхлэх программ ашиглаж байснаас төлөө АНУ-д 10.2 тэрбум ам.доллар нөхөн төлөхөөр болжээ. Өнгөрсөн онд Фольксваген корпорацийн авто машинууд хүлэмжийн хий ялгаруулалтыг бууруулан мэдээлдэг хууран мэхлэх программтай нь илэрч, олон улсад шуугиан тарьсан билээ. Энэ дуулианд холбогдсон дизель хөдөлгүүртэй авто машиныг худалдан авсан АНУ-ын 482 мянга гаруй иргэнд Фольксваген корпораци нөхөн төлбөр олгох юм байна. Нөхөн төлбөрийн хэмжээ авто машиныг худалдан авсан оноос шалтгаалж 1000-7000 ам.доллар байх талаар "Би-Би-Си" агентлаг уламжиллаа. Гэхдээ Фольксваген, АНУ-ын хооронд нөхөн төлбөрийн гэрээний талаар олон нийтэд албан ёсоор танилцуулаагүй байна. Энэ танилцуулгаас өмнө гэрээний нөхцөлд өөрчлөлт орох магадлалтайг ойрын эх сурвалжууд мэдээлжээ. Хууран мэхлэх программтай авто машинуудыг Америкийн байгаль орчны хууль тогтоомжид нийцүүлэн засварлах асуудлаар Фольксваген корпораци, тус корпорацийн үйлдвэрлэсэн авто машиныг эзэмшигчид, АНУ-ын Засгийн газар нэгдсэн саналд хүрч чадаагүй байгаатай энэ нь холбоотой юм байна.

# ИСПАНИД АЛЬ Ч УЛС ТӨРИЙН ХҮЧИН ОЛОНХИ БОЛЖ ЧАДСАНГҮЙ




Б.ДАВАА

Их Британид Европын холбооноос гарах эсэх талаарх бүх нийтийн санал асуулга болж, нийт иргэдийн 50 гаруй хувь нь “Гарах” сонголтыг хийсэн билээ. Санал асуулгын дүн гарсны дараа дэлхий нийт Испанийн парламентын сонгуулийн үр дүнг анхааралтай ажиглаж байна. Испанийн парламентын сонгуулийн санал хураалт өнгөрөгч ням гарагт болсон бөгөөд өчигдөр гэхэд үр дүн нь тодорхой болж эхэлсэн юм. Тэгвэл Европын холбоог түшиж, санхүүгийн хүнд нөхцөлд буй Испанийн сонгуульд хэт зүүний үзэл баримтлалт улстөрийн хүчин парламент дахь суудлаа нэмэгдүүлж магадгүй байна. Тус улс төрийн хүчний хувьд ЕХ-г түшиж, санхүүгийн хүнд нөхцөл байдалд байгааг идэвхтэй шүүмжилж иржээ. Сонгуулийн Ерөнхий хорооноос ирүүлсэн мэдээллээр саналын хуудсын 95.8 хувийг тоолж дуусаад байхад Испанийн Ерөнхий сайд Мариона Рахойгийн тэргүүлэх эрх баригч Ардын нам хамгийн олон буюу 32.95 хувийн санал авч, парламентын 137 суудал авах төлөвтэй боллоо. Харин Социалист ажилчны нам 22.77 хувийн санал авч, парламентын хоёр дахь том намын байр сууриа хэвээр хадгаллаа. Тус нам 85 суудал авах боломжтой ажээ. Тэгвэл Испанийг Европын холбооноос гарахыг дэмжигч хэт зүүний үзэл баримтлалт Юнидос Подемос эвсэл 21.35 хувийн санал авч гуравдугаарт эрэмбэлэгдсэн бол хэт барууны үзэлтэй “Ciudadanos” нам удаалсан байна.

Гэхдээ сонгуулийн эцсийн үр дүнгээр эрх баригч Ардын нам хэдийгээр хамгийн их хувийн санал авсан ч, олонх болж чадаагүй билээ. Энэ удаагийн сонгуульд улс төрийн намууд 350 суудалтай парламентад 176-ээс дээш тооны суудал авч байж олонх болж дангаараа Засгийн газар байгуулах учиртай. Гэвч аль ч хүчин сонгуульд олонх болж чадсангүй. Өнгөрсөн оны арванхоёрдугаар сард болсон Испанийн парламентын сонгуульд ардын нам парламентын хамгийн том нам болсон боловч дангаараа засгийн эрх барих хэмжээний олонх суудал авч чадаагүй юм. Хэдэн сар зөвшилцсөний эцэст олон нам бүлгүүд эвслийн засгийн газар байгуулах талаар нэгдсэн ойлголтод хүрч чадаагүй. Ийм учраас энэ сард дахин сонгууль хийхээр болсон. Гэсэн ч үр дүн өмнөх удаагийн санал асуулгаас нэг их хол зөрсөнгүй. Гэхдээ өнгөрөгч ням гарагийн сонгууль Их Британийн бүх нийтийн түүхэн санал асуулгын дараа болсон гэдгээрээ онцлогтой юм. Санал асуулгад британичууд гарах сонголтыг хийсний дараа ЕХ-ны бүрэлдэхүүнд түшиглэж, санхүүгийн хүндхэн байдалтай байгааг шүүмжилж ирсэн Подемос эвсэл парламент дахь суудлын тоогоо ахиулах эсэх нь анхааарал татаж байсан. Тэгвэл арванхоёрдугаар сард болсон сонгуульд 69 суудал буюу 20.66 хувийн саналыг авч байсан бол 21.35 хувийн санал авч, 71 суудал авсан байгаа юм. Харин цаашдаа Ардын нам аль намтай эвсэх, мөн эвслийн Засгийн газар байгуулж чадах эсэх нь анхаарал татаж байна.

## 14 мянган жилийн өмнөх арслан зааны яс олдлоо



Мексикийн нийслэл Мехико хотын зах хэсгийн Тультепект эртний хүмүүсийн агнасан 14 мянган жилийн өмнөх арслан зааны чулуужсан ясыг олзворлох ажил үргэлжилж байгаа ажээ. Тус чулуужсан олдвор өнгөрсөн жилийн арванхоёрдугаар сард бохир усны хоолой тавих бүтээн байгуулалтын ажлын үеэр олджээ. Археологичдын хэлж буйгаар олдворлох үйл ажиллагаа энэ оны дөрөвдүгээр сард эхэлсэн бөгөөд ойрын хугацаанд бүхэл хэсгийг татаж гаргах гэнэ. Чулуужсан яснууд 14 мянга орчим жилийн настай бөгөөд яснууд нь энд тэндгүй тарж бутарсан байгааг харвал мах болон арьс үсийг нь авахын тулд арслан зааныг хүмүүс нядалсан байж магадгүй гэж шинжээчид үзэж байна. Мөн гүехэн нуур байсан газраас арслан зааны өөр яснууд олдсон аж. Хүнд жинтэй арслан заанууд энэ нуурын шалбаагаанд шигдсэн бололтой. Мексикийн Антропологи бөгөөд түүхийн үндэсний хүрээлэнгийн археологич Луис Кордова хэлэхдээ “нийслэл Мехико хотоос холгүй орших газраас 50 гаруй арслан зааны яс өмнө нь олдож байсан” гэжээ. Тултепекийн тосгонд олдсон арслан зааны яс хоёр метрийн гүнд байжээ. Энэ амьтан 20-25 насалсан байх магадлалтайг судлаачид хэлж буй бөгөөд чулуужсан яснуудыг эвлүүлж, олон нийтэд дэлгэн үзүүлэх аж. Мексикийн хэд хэдэн мужид арслан зааны чулуужсан яс олдож байжээ.

## Дэвид Боуигийн үс, Принсийн гитар итгэмээргүй үнэ хүрчээ

Энэ он гарсаар хөгжмийн ертөнцөд мандсан урлагийн алдартай эрхмүүд цаг бусаар нас барсан хэргүүд ар араасаа гарсан. Тэдний нэг бол өнгөрөгч нэгдүгээр сард нас барсан Дэвид Боуи, дөрөвдүгээр сард нас барсан дуучин Принс нар байсан юм. Тэгвэл саяхан Д.Боуигийн үс, Принсийн гитарыг Калифорнийн Беверли Хиллст дуудлагаар худалдаалжээ. Улмаар туг үс 18750 ам.долларын үнэ хүрсэн байна. Үсийг 1980-аад оны үед Боуигийн үсний хэв маягийг лааны тосоор урлаж байсан Лондонгийн “Madame Tussauds” музейн нэгэн ажилтан хадгалж байжээ. Харин Принс агсны хайртай гитар 137.5 мянган ам.доллароор зарагдсан байна.


**ШААРДАХ ЭРХ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ ЗАР**

**“БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны зургадугаар сарын 15-ны өдрийн 233 тоот “Багануур ХК-ийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай тогтоол”-оор компанийг нэмж гаргасан хувьцааг бүртгэхийг зөвшөөрсөн бөгөөд компани нь нийт 9.870.287 /есөн сая найман зуун далан мянга хоёр зуун наян долоо/ ширхэг хувьцаа нэмж гаргахаар шийдвэрлэсэн.

Энэхүү үйл ажиллагаатай холбогдуулан 2016 оны дөрөвдүгээр сарын 18-ны өдрийн 25 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Багануур ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа эргүүлэн худалдах шаардах эрхийг хэрэгжүүлэх журам”-ыг үндэслэн, компанийн 2015 оны арваннэгдүгээр сарын 5-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож амжаагүй эсхүл хурлаас гарсан шийдвэртэй эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 53 болон 54 дүгээр зүйлд заасны дагуу өөрийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх үүсээд байна.

Иймд “Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигч та бүхэн уг шаардах эрхээ хэрэгжүүлэх бол компанид хандана уу.

**-Хувьцааг эргүүлэн худалдаж авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр:** 2015.11.05
**-Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах хүсэлт хүлээн авах эцсийн өдөр:** 2016.08.15

*“Багануур” ХК-иас хүсэлт хүлээн авах мэргэжилтний мэдээлэл:*

УЛААНБААТАР ХОТ, БАГАНУУР ДҮҮРЭГ, “БАГАНУУР” ХК-ИЙН ӨӨРИЙН БАЙР, 2 ДАВХАР, 201 ТООТ ӨРӨӨ
ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЖИЛТАН С.ОДОНЧИМЭГ, УТАС:99044373
ЭЛЕКТРОН ШУУДАН: SANJAA_OOGII@YAHOO.COM


## ЕХ-ны дээд хэмжээний уулзалтыг товлоно

Зургадугаар сарын 29-нд ЕХ-ны улсуудын удирдагчид цуглаж, тус холбооны дараагийн Дээд хэмжээний уулзалтыг Их Британийн оролцоогүйгээр хийх үү, Их Британид болсон бүх нийтийн санал асуулгын дүнг хэлэлцэх үү гэдгийг хэлэлцэнэ гэж Европын дипломат эх сурвалж ням гарагт мэдээлжээ. Эх сурвалжийн мэдээлснээр, уулзалт долдугаар сард эсвэл есдүгээр сард болох төлөвтэй байгаа аж. Их Британийн иргэдийн 51.9 хувь буюу 17.41 сая хүн пүрэв гарагт ЕХ-ноос гарахын төлөө санал өгсөн бол 48.1 хувь нь буюу 16.14 сая хүн ЕХ-нд үлдэхийн төлөө саналаа өгчээ. Энэ санал асуулгын дүнг зөвшөөрөх эсвэл цуцлах эрх парламентад байхгүй бөгөөд дахин санал асуулга болж магадгүй байна.




ШУУРХАЙ МЭДЭЭ

# ДУЛААНЫ ШИНЭЧЛЭЛ ТӨСӨЛД ХАМРАГДАХ ИРГЭДЭЭС 2-3 САЯ ТӨГРӨГ АВНА

Н.БАТЗАЯА

*"Угсармал орон сууцны дулаан техникийн шинэчлэл" төсөл хэрэгжиж эхэлсэн. Тус хөтөлбөрийн талаар НОСК-ийн захирал Б.Тэлмэнгээс зарим зүйлийг тодруулллаа.*

**-"Угсармал орон сууцны дулаан техникийн шинэчлэл" төслийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу. Ямар үе шаттай хэрэгжих вэ?**

-Улаанбаатар хотод 1970-1990 оны хооронд баригдсан 1077 угсармал орон сууцанд 46 мянга гаруй өрх амьдарч байна. Өөрөөр хэлбэл, нийслэлийн хүн амын 20 хувь нь хуучны, эдэлгээ нь алдагдсан угсармал байранд амьдарч байна гэсэн үг. Хуучны угсармал орон сууцнуудад өнөөдрийг хүртэл их засвар хийгдэж байгаагүй. Үүнээс болж дулааны алдагдал өндөр, оршин суугчид өвлийн улиралд хүйтэн байх болсон. Тиймээс "Угсармал орон сууцны дулаан техникийн шинэчлэл" төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн орон сууцны корпораци нь НИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны тавдугаар сарын 6-ны өдрийн 86 дугаар тогтоолоор энэхүү төслийн журмыг батлуулсан юм. Уг журам эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, угсармал орон сууцны оршин суугчдын ая тухтай амьдрах нөхцөл боломжоог бүрдүүлэх, тэдний хөрөнгийн үнэлэмжийг дээшлүүлэх зорилготой. Мөн эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглээг дэмжих зорилгоор дулаан техникийн шинэчлэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршиж байгаа.

**-Төслийн хүрээнд ямар зүйлийг засч өгөх вэ. Дулаан гэхлээр зөвхөн дулааны шугам сүлжээг засч өгөх үү?**

-Дулаан техникийн шинэчлэл гэж эрчим хүчний аудитын дүгнэлтийг үндэслэн, нийтийн зориулалттай орон сууцны барилгын дулааны алдагдлыг бууруулах зорилгоор хэд хэдэн ажлыг тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Тодруулбал, тухайн барилгын гадна талын ханыг дулаалах, дээвэр, хаалга цонхыг шинэчлэх зэрэг ажил хийнэ. Мөн зоорийн давхрын хучилтыг засварлаж шинэчлэх, дулаалах, хуучирч муудсан бөглөрөл ихээр бий болсон дотор системийг шинэчлэхажлыгүешаттайгаар хийж гүйцэтгэх юм.

**-Иргэд хэрхэн хамрагдах вэ?**

-Иргэд дулааны технкийн шинэчлэл төсөлд хамрагдахын тулд СӨХ-ын хурлаараа хэлэлцэн шийдвэр гаргаж, саналаа тухайн дүүргийн Засаг даргын тамгын газарт хүргүүлэх ёстой. Дүүргийн Засаг дарга нь төсөлд хамрагдах хүсэлтийг Улаанбааар хотын Захирагчийн ажлын албанд батламжлан хүргүүлнэ. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба дулаан алдагдлын зэрэглэл тогтоож, тухайн объектод тохирсон дулаан техникийн шинэчлэлийн ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыгболовсруулах юм. Үүний дараа Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба сууц өмчлөгч нь гүйцэтгэгчтэй гурван талт гэрээ байгуулж төслийг эхлүүлнэ.

**-Иргэдээс мөнгө гарах уу?**

-Нийт зургаан төрлийн ажил хийгдэж байгаа. Би дээр хэлсэн. Эдгээр ажлыг хийхэд нийт есөн сая төгрөг болно. Журамдаа есөн сая төгрөгийг хэдийг нь улсаас гаргах, хэдийг нь –"CO2" сангаас гаргах вэ гэдгийг тусгасан. Бид иргэдэд аль болох бага дарамт үзүүлэхгүй байхаар зохицуулсан. Эхний удаад 2-3 сая төгрөг иргэдээс гарна. Мэдээж огт мөнгөгүй байна гэж үгүй. Иргэд тодорхой хэмжээний хариуцлага хүлээлгэн тодорхой хэмжээний зардлыг иргэдээс авч байгаа. Харин үлдсэн зургаан сая төгрөгийг улс, нийслэл болон бусад олон улсын сангаас авахаар төлөвлөсөн.

**-Энэ төсөлд хамрагдах хүсэлт гаргаснаас хойш хэдий хугацааны дараа дулааны ажил эхлэх вэ?**

-Нэг байрыг 3-6 сарын дотор дулаална. Дулаалгын ажил хийх хугацаа тухайн байрны том, жижгээс шалтгаална. Тухайлбал, 10 орцтой байр байж болно. Мөн таван орцтой байр ч байж болно. Энэ бүхнээс л шалтгаалах байх.

**-Өвөл дулаалгын ажил хийгдэх боломжгүй. Одоо энэ төслийг хэрэгжүүлэхэд бага хугацаа үлдэж байна шүү дээ?**

-Дулаалгын ажил шууд эхлэхгүй л дээ. Эхлээд зураг төслөө гаргана. Дараа нь бэлтгэл ажлаа хангана. Зарим тохиолдолд хүмүүсийг нүүлгэх ч шаардлага гарч магадгүй. Өвлийн улиралд бид бэлтгэл ажлаа хангах юм. Зураг төслөө гаргаж, ажлын төлөвлөгөөгөө боловсруулна. Зуны улиралд багтаад хийх ажлууд байна. Тухайлбал, цонх, дээвэр шинэчлэх ажлыг хийх боломжтой.

**-Эхний удаад ямар байруудыг хамруулах вэ?**

-Нийслэлийн Засаг даргын 2016 оны зургадугаар сарын 23-ний өдрийн А/526 дугаар захирамжийн дагуу хэд хэдэн байруудад зураг, төсөв боловсруулах, их засвар хийх ажлыг эхлүүлэхээр шийдвэрлэсэн. Тухайлбал, Баянгол дүүргийн нэгдүгээр хорооны есдүгээр байр, Хан-Уул дүүргийн гуравдугаар хорооны 31 дүгээр байр, Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хорооны 10 дугаар байранд их засварын ажлыг эхлүүлнэ.

**-Иргэд материалаа бүрдүүлж өгч байна уу?**

-Иргэдматериалаабүрдүүлж өгч байна. Хэд хэдэн байрны СӨХ оршин суугчидтайгаа хурал хийж, материалаа бүрдүүлж өгсөн.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## Ихэнх нутгаар бороо орно

Өнөөдөр ихэнх нутгаар, цаашдаа нутгийн зүүн хагаст бороо орох тул үер усны аюулаас сэрэмжтэй байхыг анхааруулж байна. Тухайлбал, баруун аймгийн нутгаар салхи баруун хойноос секундэд 5-10 метр, өдөртөө нутгийн өмнөд хэсгээр секундэд 12-14 метр хүрч ширүүсч бороо орно. Харин төв аймгийн ихэнх нутгаар дуу цахилгаантай бороо орж, салхи хойноос секундэд 7-12 метр хүрч ширүүснэ. Зүүн аймгийн ихэнх нутгаар өдөртөө дуу цахилгаантай бороо орох тул иргэд, малчдыг үер усны аюулаас болгоомжлохыг анхааруулллаа.

## Зайсан-Баруун ширээт чиглэлийн аяллын замыг засч эхэлжээ

"Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрт тусгагдсаны дагуу нийслэлчүүдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлдэг гол газар болох Богд хан уулын Зайсан-Баруун ширээт чиглэлийн аяллын замыг тохижуулж эхлээд байна. Өдөрт дунджаар 1000 гаруй явган аялагчид зорчдог болсон 3.6 км урттай энэ чиглэлд түр амрах цэгүүд, замын тэмдэг тэмдэглэгээ хийж, үзэх зүйлсийн тайлбар, зарим бартаатайхэсгүүдэд хашилт, гүүр тавьж байгаа юм. Ингэснээр тухайн орчны экосистемд учирч буй сөрөг нөлөөллийг бууруулж, хөрсний элэгдлээс сэргийлэхийн зэрэгцээ аялагчдын аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдэнэ гэдгийг нийслэлийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч Ц.Энхцэнгэл танилцуулгын үеэр онцоллоо. 2015 оны байдлаар хот орчмын Богд хан уул, Горхи-Тэрэлжийн амралт, аялал жуулчлалын бүсэд аялагч, жуулчид төөрснөөс болж 300 гаруй эрэн хайх ажиллагаа зохион байгуулсан бөгөөд аялагчид гэмтэж бэртэх явдал ч цөөнгүй гардаг байсан юм. 7 дугаар сард багтаан замын засварыг дуусгана. Өнгөрсөн долоо хоногт мөн Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын Чингис уул орчмын 6 км зам, Богд хан уулын дархан цаазат газрын Төр хурахын амаас Хүрэлтогоот хүртэлх 14 км замыг хамгаалалтын захиргаанаас тогтоосон чиглэлийн дагуу Олле стандартын дагуу тохижуулах ажлыг эхлүүлсэн байна.

## Туул голын эрэг дагуу амралт зугаалгын бүс байгуулахаар болжээ

Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл "Туул голын эргийн дагуу амралт зугаалгын бүс байгуулах тухай" А/521 дүгээр захирамж гаргасан байна. Захирамжаар Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны нутаг Туул голын эргийн дагуу Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албанд 28 га газарт амралт зугаалгын бүс байгуулах зориулалтаар 15 жилийн хугацаатай газар эзэмших эрх олгожээ. Газар эзэмших эрх олгосон Захирагчийн Ажлын албатай холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Өмчийн харилцааны газарт даалгасан байна. Дээрх газарт мөрдөж буй архигүй цэнгээний газар ажиллуулах журмын дагуу хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газарт, хэв журмыг сахиулж ажиллахыг Улаанбаатар хотын Цагдаагийн газар болон Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Ганхуягт даалгажээ.

PHOTO NEWS



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН



*Хан-Уул дүүргийн 120-ын автобусны буудал орчимд шинээр байгуулсан цэцэрлэгт хүрээлэнгийн нээлт өчигдөр боллоо. Тус цэцэрлэг нь нийт 2.2 га талбай газрыг хамрах бөгөөд усан оргилуур, усан толио, амрах, нарлах талбайтай байна. Энэхүү хүрээлэн энэ нь хороолол доторхи жишиг цэцэрлэгт хүрээлэн болж буйгаараа онцлогтой ажээ.*

## 30 гаруй мянган иргэн гол ус гаталж, сонгуульд саналаа өгнө

Орон нутгийн Онцгой байдлын газар, анги байгууллагаас ирүүлсэн судалгаагаар Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн үеэр 30450 гаруй иргэн гол гаталж сонгууль өгөх гэнэ. Тодруулбал, Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд зэрэг аймгуудын 83 сумын 201 газраар 30450 гаруй иргэн голын ус гаталж, сонгуульд оролцоно гэсэн урьдчилсан мэдээ гарчээ. Иймд үер, усны ослоос урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, сонгуулийг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлэх, ард иргэд гол ус гаталж сонгуульд оролцоход аюулгүй байдлыг хангах чиглэлээр орон нутгийн Онцгой байдлын газруудад тусгайлан үүрэг хүргүүлсэн байна. Тус үүргийн дагуу орон нутгийн Онцгой байдлын газруудаас 18 завь, долоон бирвааз, нэг сэлүүрт завь, 23 автомашин гаргаж ажиллахаар бэлтгэл, бэлэн байдлыг хангаад байгаа ажээ. Мөн цаг уурын байгууллагаас ирүүлсэн мэдээгээр ойрын хоногуудад төв, зүүн зүгийн нутгаар бороошиж, ялангуяа 29-нд бороо үргэлжлэн ахиу хэмжээтэй орох, зарим үед ширүүн аадар орох төлөвтэй байна. Иймд ард иргэд амралт аялал, зугаалгаар явахдаа гол усны ойролцоо амарч зугаалахгүй, сонор сэрэмжтэй байх, бага насны хүүхдийг гол усны эрэг дагуу явуулахгүй байхыг Онцгой байдлын ерөнхий газраас анхааруулллаа.


ХҮЧИНГҮЙД ТООЦОВ

Бүтээлч шинэ сонголт ХХК-ийн нэгж талбарын 18683320209017 дугаартай, 000305327 дугаартай гэрчилгээг гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.


## Нэг настай хүүхэд машинд мөргүүлж амиа алджээ

Өнгөрсөн амралтын өдрүүдэд Улаанбаатар хотын Замын цагдаагийн газарт зам тээврийн ослын холбогдолтой 344 дуудлага бүртгэгдсэн байна. Үүнээс өнгөрсөн амралтын өдрүүдэд хөдөө орон нутгийн замд дөрвөн хүний амь нас хохирч, гурван хүн хүнд хөнгөн бэртэж гэмдсэн байна. Түүнчлэн бага насны хүүхэд амиа алдсан тохиолдол ч бүртгэгджээ. Тодруулбал, Төв аймгаас хойш 20 км-т орших Алтанбулаг сум Аргалант багийн "Хүн овоо" гэх газар шороон замд H.Sonata маркийн авто машины жолооч Х нь явган зорчигч нэг нас гурван сартай эрэгтэй А-г ухарч байгаад дайрч, амь насыг хохироосон хэрэг гарчээ. Мөн Төв аймгийн Бор нуур сумын нутаг "Урьхан" зоогийн газраас хойш нэг км-т асфальтан замд T.Nadia маркийн С жолоочтой авто машин онхолдож, жолооч 26 настай эрэгтэй С, зорчигч 19 настай эмэгтэй М нарын хоёр хүний амь нас хохирч гурван хүн гэмтсэн байна. Иймд Улаанбаатар хотын Замын цагдаагийн газраас хөдөө орон нутгийн замд хурд хэтрүүлэлгүй, болгоомжтой явахыг анхааруулллаа.

## Жингийн есөн тэмээ урлах ажил үргэлжилж байна

Хан-Уул дүүргийн нэгдүгээр хорооны нутаг дэвсгэр дэх хуучин танктай хөшөө байсан авто замын уулзварт "Торгоны зам" нэртэй жингийн таван тэмээ цувран алхаж яваа орон зайн баримал барьсан. Энэхүү баримлыг нохойгоо дагуулсан морьтой хүн , жингийн есөн тэмээ цувран алхаж байгаагаар барималчид нэмж урлан байршуулж, орчныг нь тохижуулж байгаа аж. Тохижилтын ажлын хүрээнд 120 мкв талбайд явган хүний хавтан суурилуулж, 300 ам метр талбайг зүлэгжүүлэн, 80 шар хуайс, хоёр хайлаас, 28 голтбор мод тарина. Тэмээн жин бүхий цогцолбор баримлын өндөр нь 350, урт нь 520, өргөн нь 260 см хэмжээтэй байх юм. Ази Европын орнуудын зочид төлөөлөгчид явах замд байрлаж буй энэхүү цогцолбор нь Монгол орны соёл, нүүдэлчин ард түмний онцлогийг дэлхий нийтэд харуулах ач холбогдолтой аж. Жингийн цуваанд яваа тэмээдийг өөр өөрийн онцлог бүхий хөдөлгөөнөөр алхаж байгаагаар дүрслэх бөгөөд уран барималч Ё.Далх-Очир урлаж байгаа юм.

# ЗАВСАРЛАГА

ОДДЫН ЦАГ

# ХИЛЛАРИ СВАНК:
## ДҮРҮҮД МИНЬ МИНИЙ СЭТГЭЛ ДОТОРХ ОРОН ЗАЙД ХАДГАЛААСТАЙ БАЙДАГ

Орчуулсан Б.ДАВААХҮҮ

*“Сая долларын бүсгүй” гэх киногоор манай уншигчдад илүүтэй танигдсан Оскарын хоёр удаагийн шагналт жүжигчин Хиллари Сванкийн “You're Not You” киноныхоо талаар дэлгэсэн ярилцлага “elle.co.jp” сайтнаа нийтлэгджээ. Тус ярилцлагыг өнөөдрийн “Оддын цаг” буландаа орчуулан хүргэж байна.*

**-“You're Not You” киноны гол дүрийг бүтээхийн зэрэгцээ продюссероор нь ажилласан гэсэн. Мишель Вайлдгены “Чи чи биш” зохиолын яг юунд татагдсан юм бол?**

-Юун түрүүнд зохиолыг уншихад юу юунаас ч илүү хүчтэй нэг зүйл байдаг гэдгийг хүмүүст ойлгуулсан бүтээл байна гэх бодол төрсөн. Өвчин зовлон дахь нөхөрлөлийн үнэ цэнэ, хайр дурлалын талаар өгүүлсэн зохиол байсан учир ALS өвчний талаар хүмүүст ойлгуулах сайхан боломж юм шиг санагдаж билээ. Сүүлийн үед ALS тархины өвчтэй хүмүүсийн тоо эрс нэмэгдэж байгаа ч, би өөрөө номыг унших хүртлээ юу ч мэддэггүй байсан юм билээ.

**-“Мөстэй ус асгах” чалленжаар ALS гэх тархины өвчин хүмүүст танигдсан гэж хэлж болно. Харин кинонд өвчний талаар маш нарийн зүйлсийг харуулсан байсан?**

-Би энэ зохиолыг кино болгоё гэж бодсон ганц шалтгаан нь өвчний талаар илүү их мэдээллийг хүмүүст хүргэхийг хүссэн учраас тэр. Кино гэдэг бол аливаа шинэ зүйлсийн учрыг ойлгуулах, соён гэгээрүүлэх ач холбогдолтой зүйл шүү дээ. Үүнээс гадна харилцан яриагаар дамжуулан нэг хүнээс нөгөө хүнд маш их зүйлийг ойлгуулах хүчтэй байдаг. ALS өвчний шалтгаан, эмнэлзүй нь одоо ч тодорхойгүй байгаа. Тиймээс киног маань үзээд маш олон хүмүүс энэ өвчний талаар сонирхож эхлэх болов уу гэж бодсон хэрэг.

**-Амьдрал дээр байгаа асуудлыг хөндсөн гэдэг утгаараа та маш олон өвчтэй хүмүүстэй уулзсан гэж сонссон юм байна?**

-Бүтээл нь өөрөө зохиол дээрээ үндэслэж байгаа хэдий ч, кинонд буулгахын тулд маш олон ALS өвчтэй хүмүүстэй уулзсан. Анх өвчтэй гэдгээ мэдсэнээс хойш яаж амьдарч байгаа талаарх асуултыг янз бүрийн өвчтөнүүдээс асууж, хувийн мэдээлэл цуглуулсан юм. Тэдний хувьд өвчин нь зүгээр л зохиол төдий биш бодит байдал. Хүч чадал, тэсвэр тэвчээр нь ярилцах үед харагдахгүй ч, энэ зохиолыг бодит болгоход тусалсан.

**-Таны тоглосон дүр дэлхийн бүхий л эмэгтэйчүүдэд урам зориг, хүч чадлыг өгсөн. Та энэ дүрээ ямар шалгуураар сонгосон юм бэ?**

-Магтсанд баярлалаа. Бүгд л миний бүтээлийг харж, мэдэрч байгаа. Тиймээс кино зохиолд гар хүрэх тэр үед бодогдож байсан бодол маань одоо огтхон ч өөрчлөгдөөгүй. Би өөрөө ч гэсэн энэ зохиолыг барьж ажилласнаас хойш дэлхий ертөнцийг арай өөр өнцгөөс хардаг болсон. Гол дүрийг бүтээх боломж олдсон нь миний хувьд маш том бэлэг байлаа.

**-Зан араншинг гаргахдаа хэрхэн ажилласан бэ. Таны тоглосон дүрүүд бүгд л гайхалтай. Харин энэ бүтээлд?**

-Өнөөдрийг хүртэл бүтээсэн дүрүүд маань бүгд миний сэтгэл дотор нэг орон зайд хадгалаастай байдаг. Дүр бүтээх бүрт би өөрөө янз бүрийн зүйлсийг сурч үлддэг болохоор илүү сайн хүн болоход минь тусладаг юм болов уу. Миний амьдрал улам баялаг болдог гэж хэлж ч болно. Ямар ч зохиолыг уншихдаа “үүнээс салж чадахгүй нь” гэсэн сэтгэлээр дуустал нь уншдаг. Дүрээ гаргаж ирэх бус зүгээр уншчихаад дараа нь бодоход маш гоё түүх, маш хүчтэй гол баатартай танилцсан байдаг юм. Харин тэр үед өөрийгөө азтайд тооцдог юм даа.

**-Таны дүр өөрийн тань зан араншинтэй нэлээд төстэй юм гэж олон хүн хэлж байсан шүү?**

-Тийм ээ. Олон хүн тэгж хэлсэн.



Улаанбаатарт:

Маргааш
Өдөр +18
Шөнө +8

Нөгөөдөр
Өдөр +20
Шөнө +9

### Өдрийн зурхай

**Аргын тооллын:**
*2016 оны 6-р сарын 28, Мягмар гараг*

**Билгийн тооллын:**
*Шинийн 23. Найман цагаан мэнгэтэй Цагаагчин могой өдөр.*

**Наран ургах/шингэх:**
*05:57 / 21:50*

**Үс засуулбал:**
*Эд эдлэл, идээ ундаа элбэг олдоно*



Тухайн өдөр үхэр жилтнээ аливаа үйлийг хийхэд эрэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, сан тавиулах, угаал үйлдэх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, буг дарах, газрын ам боохoд сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, сэтгэлд сэвтэй газар очих, байшингийн суурь тавихад муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, эдлэл, идээ, ундаа олно.


